

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2016 оны ажлын төлөвлөгөө (төсөл)

Уриа: Монгол Улсад 2016 он ОУИТБС-ын "ДЭД ЗӨВЛӨЛИЙГ ЧАДАВХЖУУЛАХ" жил байна.

Нэгдүгээр зорилт. ОУИТБС-ын нэгтгэл тайлан болон цахим тайлангийн систем нь олборлох салбар (уул уурхай, газрын тос, уран)-ын эдийн засаг, нийгэмд оруулж буй хувь нэмрийн талаарх бодит, цогц мэдээллийг нэг дор авахуйц найдвартай эх сурвалж болно.

Үндэслэл: Одоогийн байдлаар олборлох салбарын эдийн засагт оруулсан хувь нэмрийг тухайлбал улсын төсөвт төлсөн татвар, олборлосон, үйлдвэрлэсэн, экспортлосон бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнг Үндэсний статистикийн хороо, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар зэрэг төрийн байгууллагууд олон нийтэд мэдээлдэг ч эдгээр мэдээлэл нь өөр өөр арга зүйгээр тооцон гаргадаг, нэг дор төвлөрсөн бус, бүрэн бус байдаг. Иймээс ОУИТБС-ын стандартад зааснаар ОУИТБС-ын тайлан нь салбарын цогц мэдээллийг авахуйц бүрэн, баталгаатай байхыг шаарддаг.

Бэрхшээл: Гэсэн хэдий ч ОУИТБС-ын тайлан гаргах компаниудын тоо 2012 оноос буурч буй, Засгийн газрын болон компанийн тайлан нь аудитлагдсан санхүүгийн тоо мэдээлэлд тулгуурласан эсэхийг баталгаажуулдаггүй, нэгтгэл тайлангийн явцад компаниуд дэлгэрэнгүй, нэмэлт мэдээллийг гаргаж өгөхөөс татгалздаг, нэгтгэл тайланд орох салбарын "үндсэн мэдээллийг" боловсруулах журам байхгүйгээс төрийн байгууллагууд Хараат бус хянагч, нэгтгэгчид янз бүрийн мэдээлэл гаргаж өгдөг зэрэг бэрхшээлүүд нь ОУИТБС-ын нэгтгэл тайланг бүрэн бус мэдээлэл бүхий болгоход нөлөөлж байна.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА (УЛИРАЛ)				ХУГАЦАА (САР)	ТӨСӨВ	
			1	2	3	4		Мөнгөн дүн (төгрөг)	Эх үүсвэр
Үр дүн 1: Компанийн ОУИТБС-ын 2015 оны тайлангийн ирц 85-аас доошгүй хувьд хүрсэн байна.	1.1 Бүх компаниудад танхимын сургалт зохион байгуулах (100 хүнтэй, 3 удаа)	Мэргэжлийн холбоод, СЯ, АМГ, ТЕГ, Ажлын алба	+				2-3 сар	1,500,000	Дэлхийн банк (сургалтын зардал)
	1.2 Цахим тайлангийн системийн онлайн сургалт явуулах, видео хичээл, гарын авлагыг шинэчлэн сайжруулж, вэбсайтад байршуулах	Ажлын алба, Интерактив ХХК	+				1 сар	Гэрээт ажлын төсөв	ЕСБХБ
	1.3 Тайлан гаргах тухай зар сурталчилгааг зохион байгуулах	Ажлын алба	+				3 сар	4,000,000	Дэлхийн банк (үйл ажиллагааны зардал)
	1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ОУИТБС-ын тайлан гаргах хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх, хариуцлагыг сайжруулах ¹	ТАН	+				4 сар	-	Дэлхийн банк (зөвлөх үйлчилгээний зардал)
	1.5 Төрийн байгууллагуудтай хамтран бусад тайлан, төлөвлөгөөг тушаах явцад ОУИТБС-ын тайлангийн ач холбогдлыг сурталчилах, гарын авлага тараах	МХЕГ, АМГ, ТЕГ, Ажлын алба	+				2 сар		Дэлхийн банк (үйл ажиллагааны зардал)

¹ Иргэний нийгмийн нэмэлт санал

	1.6 Компаниудын ОУИТБС-ын 2015 оны тайланг цахимаар хүлээн авах	Ажлын алба		+			4 сар	Вэбсайтын зардал	Дэлхийн банк (үйл ажиллагааны зардал)
Үр дүн 2: Хараат бус хянагч-нэгтгэгчтэй хамтран ОУИТБС-ын стандартад заасны дагуу Засгийн газрын болон компаниудын ОУИТБС-ын 2015 оны тайлангийн болон нэгтгэл тайланд орох үндсэн мэдээллийн алдаагүй, баталгаатай, бүрэн байдлыг нэмэгдүүлж, нийтэд ил тод болгосон байна.	2.1 2015 оны нэгтгэл тайланг боловсруулах Хараат бус хянагч-нэгтгэгчийг (ХБХН) сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах, Ажлын даалгаврыг боловсруулах, тендер зарлах, үнэлэх, гэрээлэх	Үнэлгээний хороо, Ажлын алба	+				1 сар	255,000,000	Улсын төсөв
	2.2 ХБХН-тэй эхлэлтийн семинарыг зохион байгуулж тайлангийн маягт, үзүүлэлт, материаллаг босгыг зөвшилцөх, эцэслэн тохиролцох	Ажлын хэсэг	+				3 сар	Гэрээт ажлын төсөв	Улсын төсөв
	2.3 ХБХН-тэй зөвшилцсөний дагуу тайлангийн маягтыг эцэслэн боловсруулж, холбогдох байгууллагуудаар баталгаажуулах, үндсэн мэдээлэл бэлтгэх журам боловсруулж батлах	Ажлын хэсэг		+			4 сар	Гэрээт ажлын төсөв	Улсын төсөв
	2.4 2014 оны нэгтгэл тайлангаар хамгийн их зөрүүтэй тайлагнасан компаниудад танхимын сургалт зохион байгуулах (100 хүн, 1 удаа)	СЯ, АМГ, ГТГ, ТЕГ, КРМГ, Ажлын алба	+				2 сар	500,000	Дэлхийн банк (сургалтын зардал)
	2.5 2014 оны нэгтгэл тайлангаар хамгийн их зөрүүтэй тайлагнасан төрийн байгууллагуудад танхимын сургалт зохион байгуулах (60 хүн, 1 удаа)	СЯ, ТЕГ, КРМГ, Ажлын алба	+				2 сар	500,000	Дэлхийн банк (сургалтын зардал)
	2.6 Засгийн газрын тайланг аудитаар баталгаажуулах ажлыг зохион байгуулах	ҮАГ, Ажлын алба	+	+			3-4 сар	Гэрээт ажлын төсөв	Улсын төсөв
	2.7 Засгийн газрын ОУИТБС-ын 2015 оны тайланг цахимаар хүлээн авах	Ажлын алба		+			4 сар	Вэбсайтын зардал	Дэлхийн банк (үйл ажиллагааны зардал)
	2.8 ХБХН Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайланг боловсруулах, тулган баталгаажуулалт хийх, явцыг танилцуулах	Ажлын хэсэг, Ажлын алба		+	+	+	5-6, 9-10 сар	Хурал, бичиг хэргийн зардал	Дэлхийн банк (үйл ажиллагааны зардал)
	2.9 ХБХН Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайланг эцэслэн боловсруулж, батлуулах	Үндэсний зөвлөл				+	11 сар	2,000,000	Дэлхийн банк (хэвлэлтийн зардал)
Үр дүн 3: ОУИТБС-ын цахим тайлагналын системийг боловсронгуй болгож, сайжруулснаар мэдээллийн шуурхай байдал, хүртээмж нэмэгдсэн байна.	3.1. Цахим тайлагналын 2 дугаар шатны хүрээнд Татварын ерөнхий газрын цахим системтэй холбогдож мэдээлэл солилцдог болох	ҮСХ, ТЕГ, Ажлын алба, Интерактив ХХК	+				1-3 сар	300,000 евро	ЕСБХБ
	3.2 Цахим тайлагналын 2 дугаар шатны хүрээнд Ашигт малтмалын газрын цахим системтэй холбогдож мэдээлэл солилцдог болох	ҮСХ, АМГ, Ажлын алба, Интерактив ХХК	+				1-3 сар		ЕСБХБ

	3.3 Цахим тайлагналын системийн статистик, дүн шинжилгээний хэсгийг сайжруулах	ҮСХ, Ажлын алба, Интерактив ХХК		+			6 сар		ЕСБХБ
Улсын төсвийн дэд дүн								255,000,000	
Дэлхийн банкны дэд дүн								8,500,000	
ЕСБХБ дэд дүн								630,000,000	Ханш 1 €=2100₮
Нэгдүгээр зорилтын дүн								893,500,000	

Хоёрдугаар зорилт. Олборлох салбарт тусгай зөвшөөрөл олгохоос эхлээд орлогыг удирдан зарцуулах хүртэлх бүх үйл явцад ОУИТБС-ын тайлан дахь мэдээлэл нь ашиглагддаг, хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулдаг болно.

Үндэслэл: Шинээр тусгай зөвшөөрөл олгох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30%-ийг орон нутгийн хөгжлийн санд хуваарилах, орон нутагтай байгуулах загвар гэрээний төсөл батлах гэх зэрэг төр, засгаас олборлох салбартай холбоотой аливаа шийдвэр гаргахдаа ОУИТБС-ын тайлан дахь мэдээллийг төдийлөн ашиглахгүй байгаа талаар орон нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн үеэр оролцогч талууд онцолж буй. Тухайлбал ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайланд дурьдсанаар тус онд 1660 компани ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшсэн боловч 250 компани олборлох салбараас хүлээн авсан нийт орлогын 94%-ийг, бусад нь үлдэх 6%-ийг бүрдүүлсэн нь олон тусгай зөвшөөрөл олгохын эдийн засгийн ач холбогдол бага, орон нутгийн хөгжлийн санд хөрөнгө хуваарилахдаа уул уурхайтай, уул уурхайгүй сум, орон нутаг гэдгээс үл хамааран харилцан адилгүй хуваарилсан, орон нутгийн загвар гэрээний төсөл боловсруулахдаа ОУИТБС-ын хүрээнд ил тод болсон өмнөх гэрээнүүдийг судалж үзээгүй гэх зэрэг байдлаар бодлого, шийдвэр нь бодит нөхцөл байдлаас зөрүүтэй байна. Тиймээс цаашид ОУИТБС-ын тайлан дахь мэдээллийг бүх түвшинд өргөн хүрээнд ашигладаг болох нь чухал ач холбогдолтой юм.

Бэрхшээл: УИХ, Засгийн газрын түвшинд оролцоо, хүсэл эрмэлзэл бага, ОУИТБС-ын тайлан нь хэт нүсэр, ойлгоход түвэгтэй, зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан тайланг энгийн, ойлгомжтой байдлаар боловсруулах хүн хүч, санхүүжилт дутмаг, тайланг хэрхэн ашиглах талаар нийтэд хандсан заавар, аргачлал гаргадаггүй, орон нутгийн дэд зөвлөл мэдээлэл боловсруулах чадавхгүй, дэд зөвлөлд үүрэг оногдуулаагүй байна.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА (УЛИРАЛ)				ХУГАЦАА (САР)	ТӨСӨВ	
			1	2	3	4		Мөнгөн дүн (төгрөг)	Эх үүсвэр
Үр дүн 4: Бодлогын түвшинд ОУИТБС-ын тайланг ашигладаг болсон байна.	4.1 УИХ, Эдийн засгийн байнгын хороонд ОУИТБС-ын тайланг танилцуулж хэлэлцүүлэх,	Ажлын алба, зөвлөх	+			+	1, 12 сар	3,000,000	Дэлхийн банк (ажил үйлчилгээний зардал)
	4.2 УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаанд ОУИТБС-ын тайланг танилцуулж хэлэлцүүлэх,	Ажлын алба, зөвлөх	+			+	1, 12 сар	3,000,000	Дэлхийн банк (ажил үйлчилгээний зардал)

	Сангийн яам, Уул уурхайн яам, Эрдэс баялгийн бодлогын зөвлөл, судалгааны байгууллага, сэтгүүлчид гэх зэрэг зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан 2014, 2015 оны тайлангаас шаардлагатай мэдээлэл, мессежийг боловсруулах									
	4.3 Зорилтот бүлгүүдэд зориулан 2014, 2015 оны хураангуй тайлан, тараах материал, постер хэвлэн нийтлэх	Ажлын алба	+			+	1, 12 сар	5,000,000	Дэлхийн банк (хэвлэлтийн зардал)	
	4.4 Зорилтот бүлгүүдтэй албан болон албан бус уулзалт, семинар зохион байгуулах (Хөтөлбөр, удирдамж тусдаа гарна)	Ажлын хэсэг, Ажлын алба	+	+			1-6 сар	-	Дэлхийн банк (үйл ажиллагааны зардал)	
	4.5 Хэвлэлийн бага хурал, Телевизийн шууд хэлэлцүүлэг зохион байгуулах	Ажлын хэсэг, Ажлын алба	+			+	1, 12 сар	10,000,000	Дэлхийн банк (ажил үйлчилгээний зардал)	
Үр дүн 5: Загвар 4 аймаг, 6 суманд ОУИТБС-ын тайлан ашиглалтыг нэмэгдүүлж, дэд зөвлөлийг чадавхжуулах хөтөлбөр, арга зүй, сургалтын модуль, удирдамж гарсан байна.	5.1 Аймаг, сумын дэд зөвлөлийн чиг үүргийг ялгаатай тогтоож, эрх зүйн шийдвэр гаргах,	Ажлын хэсэг, Ажлын алба	+				1 сар	1,500,000	Дэлхийн банк (хэвлэлтийн зардал)	
	5.2, Дэд зөвлөлийг чадавхжуулах хөтөлбөр боловсруулах, аргачлал, сургалтын модуль, удирдамжууд боловсруулж, хэвлэх, хүргэх	Ажлын хэсэг, Ажлын алба	+				1 сар	1,500,000	Дэлхийн банк (хэвлэлтийн зардал)	
	5.3 Аймаг, сумдын ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх 2016 оны хөтөлбөр боловсруулж, аймгийн Засаг даргын үр дүнгийн гэрээнд оруулах, оролцогч талуудтай эхлэлтийн семинар зохион байгуулах	Мэргэжлийн холбоод, Аймгийн ЗДТГ, ИТХ, Ажлын хэсэг	+					1-2 сар	20,000,000	Дэлхийн банк (сургалтын зардал)
	5.4 Загвар аймаг, сумдад суурь судалгаа хийх	Ажлын алба, судалгааны компани	+					3 сар	6 000 000	Дэлхийн банк (зөвлөх үйлчилгээний зардал)
	5.5 Загвар аймаг, сумдад ОУИТБС-ын тайлан ашиглалтыг нэмэгдүүлэх зорилт бүхий компани ажлыг зохион байгуулах	Ажлын алба ТАН		+				4-6 сар	8,000,000	Дэлхийн банк (хэвлэлтийн зардал)
	5.6 Дэд зөвлөлийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулах	Ажлын алба, сургагч багш		+				4 сар	10,000,000	Дэлхийн банк (зөвлөх үйлчилгээний зардал)
	5.7 Нэгтгэл тайланд хамрагдаагүй жижиг, дунд компаниудын тайланг аудитаар тулган баталгаажуулах, хэвлэн нийтлэх	Аймгийн Аудитын газар, Ажлын алба		+				5-6 сар	Гэрээт ажлын төсөв	Улсын төсөв

Үр дүн 7: Компаниудын тайлан гаргах, уулзалт, өдөрлөгт оролцох идэвх сайжирсан байна.	7.1 Компаниудын нийгмийн хариуцлагын MNS:26001 стандартыг, /ОУИТБС-ын стандарттай нийцүүлэн хамтад нь/ мөрдөж ажиллахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	МУУҮА, Ажлын алба		+	+	+	4-12 сар	2,000,000	Дэлхийн банк (хэвлэлтийн зардал)	
	7.2 Мэргэжлийн холбоод, ИНБ- тай хамтран "Ил тод, хариуцлагатай уул уурхай" сэдэвт уулзалт, өдөрлөгийг орон нутагт зохион байгуулах	Мэргэжлийн холбоод, ИНБ, дэд зөвлөл, ажлын алба		+	+	+	+	3, 6, 9, 11	20,000,000	Дэлхийн банк (Сургалтын зардал)
Үр дүн 8: Төрийн байгууллагуудын удирдах ажилтнуудын идэвх, оролцоо нэмэгдсэн байна.	8.1 Зорилтот яам, агентлагийн дарга нарт үйл ажиллагаа, явцыг танилцуулах уулзалтууд зохион байгуулах	Ажлын алба			+	+	5, 10 сар	-	Дэлхийн банк (үйл ажилллагааны зардал)	
Үр дүн 9: Оролцогч талуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагаа, итгэлцэл нэмэгдсэн байна.	9.1 Аймаг сумын дэд зөвлөлийн дарга нарын үндэсний семинар, сургалт зохион байгуулах ²	Ажлын хэсэг, Ажлын алба, Аймгуудын дэд зөвлөл			+		10 сар	10,000,000	Дэлхийн банк (Сургалтын зардал)	
	9.2 ОУИТБС-ын 7 дугаар бага хуралд оролцох	Төлөөлөгчид, Ажлын алба		+			2 сар	34,000,000	Дэлхийн банк (Сургалтын зардал)	
	9.3 Ажлын хэсэг, дэд хэсгүүдийн хуралдаан	Ажлын алба		+	+	+	+	Улиралд 1 удаа	Хурлын зардал	Дэлхийн банк (үйл ажилллагааны зардал)
	9.4 Монгол Улсад ОУИТБС-ыг 2020 он хүртэл хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулах, хэлэлцэх, Үндэсний зөвлөлийн хуралдаанаар батлах	Ажлын хэсэг		+				1-2 сар	Хурлын зардал	Дэлхийн банк (үйл ажилллагааны зардал)
	9.5 Донор байгууллагуудтай хамтран зохион байгуулах бусад зөвлөлдөх уулзалт, лекцүүд	Ажлын алба, Донор байгууллагууд		+	+	+	+	Улиралд 1 удаа	Тухайн арга хэмжээний төсөвт зардал	Донор байгууллагууд
	9.6 Их 7-ийн үр дүнд түргэн хүрэх түншлэл хөтөлбөрийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх	ГОУХАН, Ажлын алба		+	+	+	+	1-12 сар	Тухайн арга хэмжээний төсөвт зардал	ГОУХАН
Дэлхийн банкны дэд дүн								86,000,000		
Бусад байгууллагуудын								-		

² Зүүн бүсийн семинарыг хассан байна, талууд зөвшилцөх шаардлагатай, хэрэв бүх аймгуудыг болон дэд зөвлөл бүхий сумдыг хамарсан семинар зохион байгуулах тохиолдолд төсөв хүрэлцэхгүй

	10.4.2. Гэрээний ил тод байдлын цахим хуудсанд Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг байршуулах	ГТГ, ажлын алба	+				1-3 сар	-	Дэлхийн банк (үйл ажилллагааны зардал)
	10.4.3 Олборлох үйлдвэрлэлийн чиглэлээр ажилладаг ТӨК-иудын судалгаа хийх	Ажлын алба	+				1-3 сар	төсөвлөсөн зардал	Дэлхийн банк (зөвлөх үйлчилгээний зардал)
	10.4.4 ҮСХ, Аж үйлдвэрийн яам, Уул уурхайн яамны хамтарсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	Ажлын алба			+		9 сар	-	Дэлхийн банк (үйл ажилллагааны зардал)
	10.4.5 АМГ, Монгол банк, Гаалийн ерөнхий газартай зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	Ажлын алба	+				1-3 сар	-	Дэлхийн банк (үйл ажилллагааны зардал)
	10.4.6 ТЕГ, Сангийн яамны Төрийн сан, Төсвийн орлогын хэлтсийн хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах	Ажлын алба			+		4-5 сар	-	Дэлхийн банк (үйл ажилллагааны зардал)
	10.4.7 Өөрийн үнэлгээг хийж 2015 оны үйл ажиллагааны тайланд оруулах	Ажлын алба	+				1 сар	төсөвлөсөн зардал	Дэлхийн банк (зөвлөх үйлчилгээний зардал)
	10.5 Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, ажлын алба, дэд зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн батлах, хариуцлагын тодорхой заалт оруулах	Ажлын хэсэг	+				3 сар	-	Дэлхийн банк (үйл ажилллагааны зардал)
Дэлхийн банкны дэд дүн								5,000,000	
Дөрөвдүгээр зорилтын дүн								5,000,000	

Нийт зардал		
Улсын төсөв	255,000,000	төгрөг
Дэлхийн банк	153,500,000	төгрөг
Европын сэргээн босголт хөгжлийн банк	300,000	евро
Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг	Төсөвлөсөн зардал	